

**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТӨГТООЛ**

2016 оны 03 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 2016/05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн  
бичгийн даргыг чөлөөлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, 82 дугаар зүйлийн 82.1 дэх заалтыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТӨГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Б.Цолмонг 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлж, түүний оронд Монгол шуудан хувьцаат компанийн Шуудангийн ашиглалт, технологийн газрын мэргэжилтэн Д.Цэцгээг мөн өдрөөс эхлэн томилсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг хүлээлцүүлэхийг Монгол шуудан хувьцаат компанийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Уянга, Санхүүгийн хэлтсийн дарга Θ.Сугар нарт тус тус даалгасугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллахыг Д.Цэцгээд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

---

2016 оны 03 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 2016/06

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.4 дэх заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10:00 цагт “Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын Төв Ордон”-ын хурлын бага танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсугэй:
  - 2.1 “Монгол шуудан” хувьцаат компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай,
  - 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох,
  - 2.3 Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах,
  - 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах,
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн 10:00 цагаар тогтсугай.
4. Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг хавсралт №1-ийн дагуу баталж, 2016 оны 03


дугаар сарын 07-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж”-нд хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг хавсралт №2-ын дагуу баталж, 2016 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд мэдээллэх, мөн уг зарыг 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдөр анх мэдээллэсний дагуу дахин хурлын зар хүргэхээр тогтсугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2016 оны 03 дугаар сарын 14-ны дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компанийд хургуулсугэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ч.Ганхуягийг томилсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг хавсралт №3-ын дагуу томилсугай.





“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн  
2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн  
2016/06 тоот тогтоолын Хавсралт №1

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ**

Компанийн нэр:

“Монгол шуудан” ХК

Хаяг, утас:

Монгол шуудан ХК, Сүхбаатарын талбай 1,  
Энхтайвны өргөн чөлөө, ЧД-ийн 1 дүгээр хороо  
Утас: 70078909 Факс: 330788

Хурал хуралдах огноо, цаг, газар:

“МҮЭ-ийн Соёлын төв ордон”-ын хурлын бага танхимд  
2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10:00 цагт

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:

2016 оны 03 дугаар сарын 04-ний өдөр

Олон нийтэд зарлах огноо:

2016 оны 03 дугаар сарын 09-ний өдөр

Бүртгэх өдөр:

2016 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:

2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр

Хүргүүлсэн огноо:

Хурлын баримт бичгийн хуудсын тоо .... ширхэг, .... хуудас


ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА: ..... /Б.УЯНГА/

2016 оны 03 дугаар сарын 04-ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН .....

2016 оны ..... дугаар сарын .....-ний өдөр

Дээрх мэдээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус ирүүлнэ.



“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн  
2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн  
2016/06 тоот тогтоолын Хаасралт №2

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

Компанийн оноосон нэр:

“Монгол шуудан” ХК  
Сүхбаатарын талбай 1, Энхтайвны өргөн чөлөө,  
ЧД-ийн 1 дүгээр хороо, Улаанбаатар 15160

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг:

“МҮЭ-ийн Соёлын төв ордон”-ын хурлын бага танхимд  
2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10:00 цагт

Бүртгэлийн өдөр:

2016 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- “Монгол шуудан” хувьцаат компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай
- Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдээд мэдэгдэх өдөр, журам:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл ажлын өдруудэд 09:30-17:30 цагийн хооронд 70078909 утсаар болон “Монгол шуудан” ХК-ийн төв байранд ирж ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай уулzan танилцаж болно. Эсвэл компанийн вэбсайт болох [www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn)-ийн “Хувьцаа” буланд байрлах “Хувьцаа эзэмшигчдийн хурал” цэsnээс электрон хэлбэрээр авч болно.

Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

- Компанийн санхүүгийн жилийн тайлан,
- Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт,
- Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан,
- Монгол шуудан ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл,
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**



“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн  
2016 оны 03 дүгээр сарын 04-ний өдрийн  
2016/06 тоот тогтоолын Хавсралт №3

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын  
комисс:

Комиссын дарга:      Θ.Сугар /Монгол шуудан ХК-ийн СХ-ийн дарга/  
Гишүүд:                  Б.Уянга /Монгол шуудан ХК-ийн ЗУХ-ийн дарга/  
                              н.Жавхланбаяр /Ард даатгал нэгтгэлийн аудитор/  
                              Хувьцаа эзэмшигчдийн дундаас 2 хүн сонгоно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 2016/07

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
бэлтгэл ажлыг зохион байгуулах тухай**

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.10 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын дэгийг хавсралт №1-д заасны дагуу баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт болон тэдгээрийн бэлэн болох эцсийн хугацааг хавсралт 2-т заасны дагуу баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, зохион байгуулалтын явцад хяналт тавин ажиллахыг Монгол шуудан хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Ц.Батсайханд үүрэг болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай хогбогдон гарах зардлыг “Монгол шуудан” хувьцаат компаниас санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Батсайханд зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА





**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10:00 цагт “МҮЭ-ийн Соёлын төв ордон”-ын хурлын бага танхимд болно.

- |                               |   |
|-------------------------------|---|
| 1. Бүртгэлийн үйл ажиллагаа   | /Тооллогын комисс/<br><br>09:30-09:55 Хурлын ирцыг бүртгэх<br>09:55-10:00 Тооллогын ирцийг мэдээллэх  |
| 2. Хурлын нээлт               | /Хурлын дарга Ч.Ганхуяг/<br><br>10:10-10:15 Хурлын дарга хурлыг нээх<br>10:15-10:25 Хурлын дэг батална  |
| 3. Асуудал хэлэлцэх ажиллагаа | <br>10:25-10:35 Монгол шуудан ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны товч тайлан<br>/Монгол шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Батсайхан/<br>10:35-10:45 Тайлантай холбоотой асуулт, хариулт<br>10:45-10:50 ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны товч тайлан<br><br>/ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл/<br><br>10:50-11:00 Тайлантай холбоотой асуулт, хариулт |
| 4. Хурлын завсарлага          | 11:00-11:30 Цайны завсарлага  |
| 5. Шийдвэр гаргах ажиллагаа   | <br>11:30-11:40 Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг танилцуулах,<br>шийдвэрийн төсөл хэлэлцэх<br>11:40-11:50 Санал хураалт, шийдвэр батлах<br>11:50-12:00 ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох төсөл<br>танилцуулах<br>12:00-12:10 Санал хураалт, шийдвэр батлах<br><br>/ТУЗ-ийн гишүүн Д.Дэлгэрмаа/                     |
| 6. Хаалтын ажиллагаа          | /Хурлын дарга Ч.Ганхуяг/<br><br>12:10-12:20 Хурлын шийдвэр, тогтоолыг танилцуулах<br>12:20-12:30 Хуралдааныг хааж үг хэлэх  |
| 7. Зураг авахуулах            | /Хуралд оролцогчид/<br><br>Хурал урьдчилсан байдлаар 3 цаг үргэлжилнэ.  |



“Монгол Шуудан” ХК-ийн ТУЗ-ийн  
2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн  
2016/07 тоот тогтоолын Хавсралт №2

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар  
хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт болон  
тэдгээрийн бэлэн болгох хугацаа

№	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээлэл	Бэлэн болгох хугацаа
1	“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон хавсралтууд	2016 оны 03 дугаар сарын 07-ны өдөр
2	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл	2016 оны 03 дугаар сарын 07-ны өдөр
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар	2016 оны 03 дугаар сарын 09-ний өдөр
4	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг	2016 оны 03 дугаар сарын 07-ны өдөр
5	“Монгол шуудан” ХК-ийн 2015 оны санхүүгийн тайлан	2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр
6	“Монгол шуудан” ХК-ийн 2015 оны Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын дүгнэлт	2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр
7	“Монгол шуудан” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга	2016 оны 04 дугаар сарын 08-ний өдөр
8	“Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга	2016 оны 04 дугаар сарын 08-ний өдөр
9	“Монгол шуудан” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл	2016 оны 04 дугаар сарын 08-ний өдөр
10	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, 2016 оны зардлын төлөвлөгөөний төсөл	2016 оны 04 дугаар сарын 08-ний өдөр

**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 2016/08

Улаанбаатар хот

Нэр дэвшүүлэх хороог байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хорооны дарга: Д.Дэлгэрмаа /ТҮЗ-ийн гишүүн/

Гишүүд: Б.Наранбаатар /ТҮЗ-ийн гишүүн/

Ж.Оюунгэрэл /ТҮЗ-ийн гишүүн/

Л.Чинбат /ТҮЗ-ийн хараат бус гишүүн/

Б.Амарсанаа /ТҮЗ-ийн хараат бус гишүүн/

2. Хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллаж,  
Хорооны ажиллах журмыг боловсруулан батлуулахыг Нэр дэвшүүлэх хороо  
/Д.Дэлгэрмаа/-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 2016/09

Улаанбаатар хот

Аудитын дэд хороог байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.2, 81.4 дэх заалтыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөллийн дэргэдэх Аудитын хороог дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хорооны дарга: Л.Ундаргаа /ТҮЗ-ийн хараат бус гишүүн/

Гишүүд: Ч.Ганхуяг /ТҮЗ-ийн гишүүн/

Б.Амарсанаа /ТҮЗ-ийн хараат бус гишүүн/

2. Хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллаж, Хорооны ажиллах журмыг боловсруулан батлуулахыг Аудитын хороо /Л.Ундаргаа/-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 2016/10

Улаанбаатар хот

Цалин, урамшуулалын хороог байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороог дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хорооны дарга: Б.Батзаяа /ТҮЗ-ийн гишүүн/

Гишүүд: Л.Чинбат /ТҮЗ-ийн хараат бус гишүүн/

Л.Ундаргаа /ТҮЗ-ийн хараат бус гишүүн/

2. Хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллаж, Хорооны ажиллах журмыг боловсруулан батлуулахыг Цалин урамшууллын хороо /Б.Батзаяа/-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ